

Chat өрөө

Вася нэг chat room-д ороод бүх хүмүүст *hello* гэж хэлэхийг хүсчээ. Гэвч түүний компьютерийн гар бага зэрэг эвдэрсэн тул заримдаа түүнийг бичиж байхад өөр үсгүүд хамт дарагддаг болчихсон байна. Тэгвэл түүний бичсэн үг *hello* байх боломжтой эсэхийг тогтоо. Жишээлбэл Вася "ahhellllloou" гэж бичсэн бол эндээс зарим үсгүүдийг компьютерийн гарны эвдэрлээс болж өөрөө дарагдсан гэж үзээд устгавал *hello* гэсэн үг үүсч байна. Харин "hlelo" гэж бичсэн бол Вася *hello* гэж бичсэн байх боломжгүй гэсэн үг юм.

Input

Латин цагаан толгойн жижиг үсгүүдээс бүтэх ганц үг байх ба үгийн урт нь 1-ээс багагүй 100-аас ихгүй байна.

Output

Вася *hello* гэж хэлсэн байх боломжтой бол "YES" эсрэг тохиолдолд "NO" гэж гарга.

Example

Input 1:

ahhellllloou

Output 1:

YES

Input 2:

hlelo

Output 2:

NO